



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН
ХӨНДЛӨНГИЙН ТОЙМ ДУГНЭЛТ



“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО” ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ТОЙМ ДҮГНЭЛТ

Судалгааг хийж гүйцэтгэсэн: Санхүүгийн эдийн засагч А.Батпүрэв

Шүүмж өгсөн зөвлөх: Эдийн засагч Н.Энхбаяр

Редактор: Д.Оюунбадам (PhD)

УЛААНБААТАР

2022 ОН

ННА 65
ДАА 330
Б-33



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”

ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН
ХӨНДЛӨНГИЙН ТОЙМ ДҮГНЭЛТ

Судалгааг хийж гүйцэтгэсэн: Санхүүгийн эдийн засагч А.Батпүрэв
Шүүмж өгсөн зөвлөх: Эдийн засагч Н.Энхбаяр
Редактор: Д.Оюунбадам (PhD)

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9840-3-8

© Нээлттэй Нийгэм Форум, 2022

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	5
СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА	7
Үндэслэл	7
Судалгааны зорилго	9
Судлагдахууны хамрах хүрээ	9
Арга зүй	10
1. АСУУДЛАА ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	12
Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал	12
Тулгарч буй асуудлууд	14
2. ЗОРИЛТУУДАА ДЭВШҮҮЛСЭН БАЙДАЛ	19
3. БОДЛОГЫН ЧИГЛЭЛҮҮДЭЭ СОНГОСОН БАЙДАЛ	30
Бодлогын чиглэлүүд	30
Олон улсын туршлага: Ирланд Улсын жишээ	33
4. БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУРУУД, ДҮГНЭЛТ	35
Хамаарал	36
Оновчтой, Үр ашигтай байдал	37
Хэрэгжих боломж	39
Тогтвортой, Үр нөлөөтэй байдал	41
Ашигласан эх сурвалж	43
Хавсралт	44

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засгийн “Ковид-19 Эмзэг байдлын индекс”	14
Хүснэгт 2. Шинэ сэргэлтийн бодлогын төсөлд эдийн засгийн асуудлуудыг хамарсан байдал	15
Хүснэгт 3. Монгол Улсад тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэхээр дэвшүүлсэн зорилтууд	22
Хүснэгт 4. Тэнхээтэй, тогтвортой, хүртээмжтэй сэргэлтийн бодлогын бүтэц, ЭЗХАХБ	31
Хүснэгт 5. Ирланд Улсын Эдийн засгийн сэргэлтийн төлөвлөгөө	33

ӨМНӨХ ҮГ

Дэлхий даяар тархсан КОВИД-19-ын цар тахал нь уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, өргөн хэрэглээний барааны импортоос ихээхэн хамааралтай Монгол Улсын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлээд байна. Эдийн засгийн агшилт нь ажилгүйдэл, ядуурал, хүн амын орлогын тэгш бус байдал нэмэгдэх зэрэг эрсдэл бий болголоо.

КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөөг бууруулах үүднээс дэлхийн улс орнуудын Засгийн газар төрөл бүрийн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Манай улс ч энэ зорилгоор 2021 оны 12 дугаар сард “Шинэ сэргэлтийн бодлого” хөтөлбөр боловсруулж баталсан юм. Энэхүү хөтөлбөрт судлаач А. Батпүрэвийн хийсэн хөндлөнгийн тойм дүгнэлтийг энэхүү хэвлэн нийтлэлээр уншигч Танд танилцуулж байна. Судлаачийн зүгээс манай улсад тулгарч буй асуудлыг хэрхэн оношилж, шийдвэрлэх оновчтой хувилбар дэвшүүлсэн эсэхэд төвлөрч олон улсын практиктай харьцуулан санал, дүгнэлт гаргасан болно.

“Шинэ сэргэлтийн бодлого” нь дунд-урт хугацааны асуудлыг шийдвэрлэхэд түлхүү чиглэн, богино хугацаанд тулгамдсан нэн чухал асуудлуудыг орхигдуулсан болохыг судлаач дүгнэжээ. Үүнд, уул уурхайн салбараас хамаарах эдийн засгийн савлагааг бууруулах, жижиг дунд бизнесийг хамгаалах, сэргэлтийг дэмжих, тэгш бус байдлыг бууруулах, дундаж давхаргыг хамгаалах, төсвийн бодлогыг тогтворжуулах, алдагдал, өрийг бууруулах, тэтгэвэр, нийгмийн даатгалын шинэчлэл хийх зэрэг асуудлыг голлон дурджээ. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг цаашид үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийн талаар судлаачийн гаргасан зөвлөмжийг бодлого боловсруулагчид анхааран авч үзнэ гэдэгт найдаж байна.

Судалгааг хийж гүйцэтгэсэн А.Батпүрэв, судалгааны тайланг сайжруулахад үнэтэй санал шүүмж өгч ажилласан хөндлөнгийн шинжээч Н.Энхбаяр, ННФ-ын ажилтан Д.Оюунбадам нарт талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Үндэслэл

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөлөөгөөр Монгол Улсын ДНБ-ийн хэмжээ 2020 онд 37.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит дүнгээр 4.6 хувиар агшсан. Харин 2021 оны эхний хагас жилд бодит ДНБ 12.5 их наяд төгрөгт хүрч, эдийн засаг өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсжээ. Салбараар авч үзвэл 2021 оны эхний хагас жилд уул уурхайн салбар 24.3, үйлчилгээний салбар 3.0 хувиар тус тус өссөн бол хөдөө аж ахуйн салбар 4.6 хувиар буурчээ. Гэвч гадаад худалдааны нөхцөл байдалтай холбоотойгоор уул уурхайн салбарын борлуулалт, түүнийг дагаад экспортын өсөлт, төсвийн орлого оны хоёрдугаар хагаст буурсан байна.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд цар тахлаас үүдэлтэй гэнэтийн шок Монгол Улсын эдийн засгийн өрөөсгөл бүтцийн сул талыг улам гүнзгийрүүлсэн билээ. Манай улсын эдийн засаг том дүнгээрээ сэргэж буй мэт боловч дийлэнх салбарт хямрал үргэлжлэн ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх эрсдэл өндөр хэвээр байна. Ядуурлын түвшнийг тодорхойлох хамгийн сүүлийн судалгаагаар хүн амын 28.4 хувь нь ядуу байгаагийн дээр 15 орчим хувь нь ядуурлын шугамын ойролцоо буюу ядууралд өртөх эрсдэлд байна.

Мөн эдийн засгийн өсөлтийн бааз суурь хумигдсан, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муу буюу жигд бус, боловсролын чанарын ялгаа өндөр, санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалттай түвшинд хүрээгүй буюу гүнзгийрүүлэн сайжруулах шаардлагатай, тогтвортой хөгжлийн асуудал тулгамдсан хэвээр байгаа зэрэг сорилтууд Монгол Улсын эдийн засгийн өмнө тулгарч буйг олон улсын байгууллагууд онцолжээ. Улсын төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн суурь тогтолцоо сул байгаа нь эдийн засгийн хөгжилд саад учруулж байгааг Азийн Хөгжлийн Банкны

“Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээ”-нд дурджээ (АХБ, 2021). Орлогын төсөөллүүд хэт өөдрөг хийгддэгээс жилийн явцад ойр ойр төсвийн тодотгол хийгдэх, төсвийн тэнцлийн зорилтууд байнга зөрчигдөх байдал хэвийн болсны дээр зарлагыг хянах танах, төсвийн бодлогыг эдийн засгийн савлагаанд илүү дархлаатай болгох тал дээр авч хэрэгжүүлж буй зөв алхмуудад төсвийн гадуурх зарцуулалт садаа болсоор өнөөг хүрлээ. Төсвийн төлөв суларсантай холбоотойгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн үзүүлэлт 2020 онд 6.7 нэгж хувиар муудаад байна.

2021 оны 1-3 дугаар сард 2.5 хувь орчимд тогтвортой байсан инфляцын түвшин 4 дүгээр сараас эхлэн нэмэгдэж оны эцэст хоёр оронтой тоо давлаа. Цаашид гадаад худалдаа, тээвэрлэлттэй холбоотой нийлүүлэлтийн шок, мөнгөний тэлэх бодлогын нөлөөгөөр инфляцын эрсдэл өндөр байхаар дүр зураг харагдаж байна.

Ийнхүү КОВИД-19 цар тахлын эдийн засгийн сөрөг үр нөлөөг зөөлрүүлэх зорилгоор Монгол Улсын авч хэрэгжүүлсэн мөнгөний болон төсвийн бодлогын орон зай шавхагдаж буй тул цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих, өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлого хэрэгжүүлэх нь нэн чухал юм.

Засгийн газраас 2022 онд хөгжлийн төслүүдийг эхлүүлэх, хүртээмжтэй өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих замаар эдийн засгийг сэргээх шинэчлэл хийнэ хэмээн мэдэгдээд буй. Энэ хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлого” хэмээх эдийн засгийн хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан, 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хурал (УИХ)-аар хэлэлцүүлэхээр өргөн баримагц уг хөтөлбөрийг ажлын гурван өдрийн дотор баталжээ.

Уг бодлогын агуулгын хүрээнд баримталж буй бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ нь тулгарч буй асуудлыг хэрхэн оношилж, шийдвэрлэх оновчтой хувилбар дэвшүүлсэн эсэхэд төвлөрч олон улсын практиктай харьцуулан санал, дүгнэлт өгөх үүднээс энэхүү хөндлөнгийн тойм судалгааг хийж гүйцэтгэв.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлого” хөтөлбөрт тусгагдсан бодлогууд хэр оновчтой, тэдгээр нь төсөв, мөнгөний бодлогын зарчмуудтай хэр уялдаж буйд дүн шинжилгээ хийхээс гадна олон улсын ижил төстэй хөтөлбөртэй харьцуулан судалж, хөндлөнгийн дүгнэлт, зөвлөмж боловсруулах үндсэн зорилго тавьж ажиллалаа.

Уг зорилгын хүрээнд судалгааны дараах асуултуудад хариулт өгөх зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Ковид-19 цар тахлын улмаас Монгол Улсын эдийн засагт ямар гол асуудлууд бий болсон, түүний үр дагавар юу вэ?
2. Засгийн газраас санал болгож бодлогын баримт бичигт уг асуудлыг хэрхэн авч үзсэн байна вэ?
3. Энэ төрлийн бодлогын хувилбаруудыг үнэлэх гол шалгуурууд нь юу байж болох вэ?
4. “Шинэ сэргэлтийн” бодлогын хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон арга хэмжээнүүдийг тэдгээр шалгуураар үнэлэхэд ямар дүр зураг харагдаж байна вэ?
5. Дэлхийн бусад улс орон Ковидын үеийн эдийн засгаа сэргээх чиглэлээр бодлогын ямар арга хэмжээ авч байна вэ? Эдгээрээс Монгол Улс юуг сурч болохоор байна вэ?
6. Коронавируст цар тахлын үеийн эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төслийг чанаржуулах бодлогын ямар санал, зөвлөмж байж болох вэ?

Судлагдахууны хамрах хүрээ

1. “Шинэ сэргэлтийн бодлого”

Засгийн газраас 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдөр УИХ-д өргөн барьсан төсөл (Засгийн газар, 2021). Уг төслийг өргөн барихаас өмнө мөн Ковид-19 цар тахлын үеийн эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төслийг Сангийн Яамнаас боловсруулж бусад яамны

саналыг авсны үндсэн дээр УИХ-д өргөн барихаар болоод байсан ч түүнийг уг бодлоготой нэгтгэн хуулийн хүрээг хумьсан байна. “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дагалдан үе шаттайгаар өргөн мэдүүлэх хуулийн төслийн жагсаалтад “Эдийн засгийн сэргэлтийг дэмжих хөгжлийн төслийг санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх тухай анхдагч хуулийн төсөл” гэж оржээ.

2. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсөв, Төрөөс мөнгөний талаар баримтлах бодлого-2022

УИХ-д өргөн баригдсан Монгол Улсын 2022 оны төсвийн төсөл, Мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөл болон тэдгээрийн дагалдах танилцуулгад мөн Ковид-19-ийн эдийн засагт үзүүлсэн нөлөө, цаашид учирч болох эрсдэлүүдийн талаар хэрхэн авч үзсэн байдал.

3. Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх чиглэлээр гадаад орнуудын авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээтэй холбоотой бусад судалгааг харьцуулан судлав.

Арга зүй


Хөндлөнгийн анализ нь тавигдаж буй судалгааны зорилгын хувьд хэрэгжүүлэлтийн өмнөх бодлогын үнэлгээний (*ex-ante policy evaluation*) шинж чанарыг агуулж байгаа тул норматив чанарын судалгааны түгээмэл арга болох бичиг баримтын шинжилгээ, кэйс судалгааны аргачлалуудаас ашиглахаар төлөвлөсөн.

Боломжит өгөгдөл, цаг хугацаа, нөөц зэрэг хязгаарлалтын улмаас Зураг 1-д дүрсэлсэн бодлогын төслийг үнэлэх үе шатуудыг иж бүрнээр нь гүйцэтгэх боломжгүй байсан бөгөөд ерөнхий зарчмыг баримтлан үнэлэлт өгөхийг хичээлээ. Нөгөө талаар “Шинэ сэргэлтийн бодлого” нь эдийн засгийн олон секторыг хамарсан, нийтлэг бүх асуудалд хамаатай, олон талт хөтөлбөр бүхий бодлогын баримт бичгийн шинжтэй тул олон хувилбар гарган харьцуулж үнэлэх боломж багатай юм.

Зураг 1. Бодлогын шинжилгээний дараалал ба бодлогын төслийг үнэлэх үе шат

Нийтийн бодлогын шинжилгээний зургаан алхам

Бодлогын төслийг үнэлэх үе шатууд



I. АСУУДЛАА ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Коронавируст цар тахлаас үүдэлтэй богино хугацааны эдийн засгийн эрсдэлийг хэмжиж олон улсын түвшинд харьцуулах хамгийн энгийн бөгөөд оновчтой аргачлалын нэг нь Европын хөрөнгө оруулалтын банкнаас гаргасан “Ковид-19 Эмзэг байдлын индекс”¹ юм. Уг аргачлалаар 2020 оны эцэст Европын холбооны гишүүн бус 140 улсын Ковид-19 Эмзэг байдлын индексийг (Davradakis & et.al, 2020) гурван бүлэг есөн индикатораар харьцуулан үнэлсний дотор Монгол Улс багтсан байна. Нэгдсэн индексийн дүнгээр нийт 140 улсын 28 хувь нь өндөр эрсдэлтэй буюу маш эмзэг, 11 хувь нь бага эрсдэлтэй харин үлдэх 61 хувь нь эмзэг байдал дундаж буюу дунд зэргийн эрсдэлтэй гэж гарсны дотор Монгол Улс багтжээ (Зураг 2).


Монгол Улсын индексийн үнэлгээг бүрдэл хэсгүүдээр нь задалж үзвэл цар тахал зэрэг шокод өртөмхий байдал болон түүний эсрэг эдийн засгийн бодлогын хариу арга хэмжээ авах боломжийг илэрхийлсэн хоёр үзүүлэлтээр “маш өндөр эрсдэлтэй” гэсэн ангилалд орсон байна. Үүнд төсвийн бодлогын хариу үйлдэл үзүүлэх чадавхыг илэрхийлэх Засгийн газрын өрийн хэмжээ, циклээс хамаарах эрсдэлийн түвшинтэй шууд хамааралтай түүхий эдийн экспортын хувь хэмжээ гэсэн хоёр индикатор орж байна.

Харин эрүүл мэндийн систем ба хүн ам зүйн бүтцийг илэрхийлэх 1000 хүн тутамд ногдох эмчийн тоо, эмнэлгийн орны тоо, 65-аас дээш насны хүн амын эзлэх хувь зэрэг багц үзүүлэлтүүд болон олон улсын үнэ цэнийн сүлжээнд эзлэх хувь (*global value chain participation*), аялал жуулчлалын салбарын эзлэх хувь, мөнгөн гуйвуулгын орох урсгал гэсэн индикаторуудаар “эрсдэл багатай” гэж дүгнэгдсэн нь нэгдсэн үнэлгээ “эмзэг байдал дунд зэрэг” гэж гарахад нөлөөлсөн байна.

1 https://www.eib.org/attachments/thematic/the_eib_covid-19_economic_vulnerability_index_en.pdf

Хүснэгт 1-д индексийн бүрдэл хэсгүүд, тэдгээрийг үнэлэхэд ашигласан индикаторуудын задаргааг харуулав.

Зураг 2. Ковид-19 Эдийн засгийн эмзэг байдлын нэгдсэн индекс улс орнуудаар



Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засгийн “Ковид-19 Эмзэг байдлын индекс”

Үзүүлэлт	Индикатор	Өндөр	Дунд	Бага
<i>Нэгдсэн</i>				
<i>Эрүүл мэндийн систем ба Хүн ам зүй</i>	1000 хүнд ногдох эмч, эмнэлгийн орны тоо, 65-аас дээш насныхны эзлэх хувь			
<i>Глобал үнэ цэнийн сүлжээ</i>	Олон улсын үнэ цэнийн сүлжээ дэх оролцоо/ДНБ (UNCTAD)			
<i>Аялал жуулчлал</i>	Салбарын орлого/ДНБ			
<i>Гуйвуулга</i>	Гадаадаас орох хувийн гуйвуулга/ДНБ			
<i>Таваарын экспорт</i>	Түлш, металл, баяжмал зэрэг эрдэс баялгийн экспорт/ДНБ			
<i>Капиталын гарах урсгал</i>	Урсгал болон хөрөнгө оруулалтын дансны тэнцэл/ДНБ			
<i>Төсвийн боломж</i>	ЗГ-ын өр/ДНБ, дистресс эрсдэл			
<i>Банкны салбарын эрсдэл</i>	Banking Industry Risk (BIR) score	Мэдээлэл байхгүй		

Тулгарч буй асуудлууд

Эмзэг байдлын индекс нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор тухайн эдийн засагт тулгарч буй богино хугацаанд анхаарах шаардлагатай асуудлуудыг тодруулж өгч буйгаараа ач холбогдолтой юм. Тодруулбал, эрдэс баялгийн экспортоос хамааралтай байдал, төсвийн бодлогын орон зай хомс, банк санхүүгийн салбарын эрсдэлд анхаарал хандуулахгүй байгаа явдал нь Монгол Улсын эдийн засаг цар тахал мэтийн гэнэтийн шокийн үед эмзэг болох үндэслэл болж байна. Монгол Улсын хувьд богино, дунд хугацаанд зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн асуудлуудыг дотоодын болон олон улсын судлаачид, судалгааны байгууллагуудын тодорхойлсноор Хүснэгт 2-т тоймлон харуулав. Мөн Ковид-19 цар тахлын

дараах “Шинэ сэргэлтийн бодлого”-д ямар асуудлуудыг дэвшүүлж тэдгээрт чиглэсэн ямар бодлого дэвшүүлж буйг тоймлон харьцууллаа.

Тулгарч буй асуудлуудыг жагсаахдаа Азийн Хөгжлийн Банкнаас хэвлүүлсэн “Монгол Улсын хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээ 2017-2020” (АХБ, 2021), Дэлхийн банкны “Монголын эдийн засгийн тойм: Тусламж дэмжлэгээс өсөлт өөд” (ДБ, 2021) судалгааны ажлууд, Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх төсвийн зөвлөлийн “Цар тахлын үеийн төсвийн бодлого” бодлогын тойм (А.Батпүрэв, 2021) болон Монгол Банкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очирын “Монголын хөгжлийн зам: Сургамж, сорилт, боломж” (Д.Ган-очир, 2020) бүтээлүүдээс тоймлон ашиглав.

Хүснэгт 2. Шинэ сэргэлтийн бодлогын төсөлд эдийн засгийн асуудлуудыг хамарсан байдал

Тэмдэглэгээ: ☑ - Тухайн асуудлыг шууд хамарсан; ☒ - Тухайн асуудалтай ямар нэг байдлаар холбоотой буюу хэсэгчлэн хамарсан; ☓ - Тухайн асуудлыг хууль, бодлогын төсөлд авч үзээгүй.

	АСУУДАЛ	ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО	Хамарсан түвшин
	Гадаад худалдааны бараа эргэлт буурсан	Боомтууд	☑
Гадаад секторын асуудлууд	Хилийн боомтын хямрал		☑
	Төлбөрийн тэнцэл сул		☑
	Гадаад өр өндөр		☓
	Гадаадын хөрөнгө оруулалт унасан		☓

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Эдийн засгийн бүтцийн асуудлууд	Хүн ам, бизнесийн төвлөрөл түүнийг дагасан УБ хотын асуудлууд	Хот, хөдөөгийн ялгаа, УБ хотын замын түгжрэл	☑
	Эрдэс баялгаас өндөр хамааралтай эдийн засаг, экспорт	Аж үйлдвэржилт	☑
	Аж үйлдвэрийн хөгжил, нэмүү өртөг шингээх үйлдвэрлэл		☑
	Эрчим хүчний хомсдол, нийлүүлэлтийн хараат байдал	Эрчим хүчний дутагдал,	☑
	Дэд бүтцийн сул хөгжил	УБ хотын дэд бүтэц	☑
Бизнесийн сектор	Нийлүүлэлтийн гинжин хэлхээ тасалдсан		☑
	Үйлдвэрлэлийн хэмжээ буурсан		⊗
	Жижиг дунд бизнес хумигдсан		⊗
	Дотоод хөрөнгө оруулалт хумигдсан		⊗
	Аялал жуулчлалын салбар зогссон	Ногоон хөгжил, аялал жуулчлал	☑
Өрхийн сектор	Дотоод эрэлт багассан		⊗
	Ажил эрхлэлт буурсан		☑
	Ажиллах хүчний оролцоо бага, олон иргэн, ялангуяа эмэгтэйчүүд ажиллах хүчний эгнээнээс гарсан, чадварлаг мэргэжилтэй ажилтны нийлүүлэлт хомс		⊗
	Тэгш бус, хүртээмжгүй байдал гүнзгийрсэн (орлого, боловсрол, эрүүл мэнд)		⊗
	Шинээр ядуусын эгнээнд шилжигсдийн хувь өссөн, хотын ядуурал нэмэгдсэн		⊗
	Дундаж давхарга бага бөгөөд эмзэг		⊗

Хүснэгт 2-ын үргэлжлэл

Төрийн сектор	Төсвийн орлого ихээр тасалдсан, бааз хумигдсан	⊗
	Зарлага хэт өссөн (зорилтот бус, тэвчиж болох зардлууд буураагүй)	⊗
	Төсвийн төлөвлөлт цикл дагасан хэвээр	⊗
	Улсын болон ЗГ-ын өр огцом өссөн	⊗
	Нийгмийн даатгалын тогтолцоо хямарсан, халамжийн зардал өндөр	⊗
	Төрийн өмчит компаниудын эрсдэл, төсвийн шинжтэй зарлага өндөр	☑
	Авлига, бизнес дэх төрийн оролцоо өндөр	☑
	Төрийн бүтээмж	
Мөнгө, санхүүгийн сектор	Инфляц эрс өссөн, мөнгөний бодлогын орон зай бага	⊗
	Гадаад валютын нөөц хангалтгүй, төлбөрийн тэнцэл сул	☑
	Зээлийн чанар муудсан, санхүүгийн салбар эмзэг байдалтай	⊗
	Монгол банкны хараат бус байдал алдагдсан	⊗

Дээр дурдсан эх сурвалжуудад давтамжтайгаар дурдагдсан асуудлуудаас Монголын эдийн засагт богино болон дунд хугацаанд тулгарч буй 32 асуудлыг жагсаан, зургаан бүлэгт ангилснаас “Шинэ сэргэлтийн бодлого”-д 10 асуудал буюу 32 хувийг нь авч үзэж шийдвэрлэх хүрээнд асуудлаа дэвшүүлсэн байна. Мөн дөрвөн асуудлыг бусад асуудалтай холбоотойгоор ямар нэг байдлаар хөндсөн гэж үзэж болохоор байгаа бөгөөд үлдсэн 18

асуудал буюу 56 хувь нь огт хөндөгдөөгүй байна. Тухайлбал, гадаад өрийг бууруулах, төсвийн зардлыг бууруулж хөрөнгө оруулалтын удирдлагыг чанаржуулах, хуримтлал үүсгэх замаар төсвийн бодлогын чадавхыг бэхжүүлэх, Төв банкны хараат бус байдлыг бэхжүүлж төсвийн шинжтэй хөтөлбөрүүдээс гарган санхүүгийн системийн тогтвортой байдлыг бэхжүүлэх асуудлыг төсөлд оруулаагүй байна. Түүнчлэн инфляц, гадаад валютын ханшийн өсөлтийн эсрэг мөнгөний бодлогын чадавх бүрдүүлэх, нийлүүлэлтийн гинжин хэлхээг богино хугацаанд сэргээж бизнес секторыг дэмжих, ажиллах хүчний шилжилтийг бүтцийн өөрчлөлттэй уялдуулан зохион байгуулах гэх мэт асуудлуудыг “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төсөлд онилоогүй байна.

2. ЗОРИЛТУУДАА ДЭВШҮҮЛСЭН БАЙДАЛ

Дээрх тулгамдсан асуудлуудтай холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт богино болон дунд хугацаанд зайлшгүй шийдвэрлэх ёстой сорилтуудыг тодорхойлж болно. Доорх хүснэгтэд тодорхойлсон сорилтуудыг шийдвэрлэх нь эдийн засгийн сэргэлтийн бодлогын зорилт болох учиртай. Хэдийгээр нэг бодлогын баримт бичгээр бүх сорилтыг шийдвэрлэх зорилт тавих нь хүндрэлтэй боловч “Шинэ сэргэлтийн бодлого” нь 10 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд “Ковид-19 цар тахалтай үргэлжлүүлэн тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагаврыг арилган хүндрэлийг даван туулахын зэрэгцээ Монгол Улсын хөгжлийг урт, дунд хугацаанд хязгаарлаж буй асуудлуудыг шийдвэрлэх” гэж зорилгоо тодорхойлсон тул аль болох олон бэрхшээл сорилтод хариулт өгөх иж бүрэн шинжтэй байх шаардлагатай юм.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд дэвшүүлсэн зорилт болон хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь тулгамдсан асуудалд үндэслэн тодорхойлсон 37 сорилтын 20 буюу 54 хувийг ямар нэг байдлаар шийдвэрлэх агуулгатай байна. Харин дор дурдсан 15 зорилт орхигджээ. Үүнд:

- Уул уурхайн салбараас хамаарах эдийн засгийн савлагааг бууруулах;
- Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, диверсификацлах;
- Жижиг дунд бизнесийг хамгаалах, сэргэлтийг дэмжих;
- Ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ялгаварлалыг бууруулах;
- Нийгмийн халамжийг зорилтот бүлгүүдэд чиглүүлэх;
- Ядуурлыг бууруулах;

- Тэгш бус байдлыг бууруулах, дундаж давхаргыг хамгаалах;
- Төсвийн бодлогыг тогтворжуулах, алдагдлыг бууруулах;
- Төсвийн тэлэлтийг сааруулж өрийг бууруулах;
- Улсын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- Тэтгэвэр, нийгмийн даатгалын шинэчлэл хийх;
- Улсын секторын өрийн эрсдэлийг бууруулах, гадаад төлбөрийг дахин санхүүжүүлэх;
- Мөнгөний бодлогын чадавх бүрдүүлэх;
- Монгол банкны тэнцлийг аливаа төсвийн шинжтэй хөтөлбөрт оролцуулахгүй байх, бодлогын бие даасан байдлыг хангах.

Мөн аялал жуулчлалын салбарыг сэргээн хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих татварын шинэчлэл хийх, хөрөнгө зах зээлийг дэмжих чиглэлээр зорилго дэвшүүлсэн гэх боловч хөтөлбөрийн төсөлд тодорхой арга хэмжээ тусгагдаагүй, дагалдан гарах хууль тогтоомжуудаар зохицуулагдана гэсэн байна. Өмнө боловсруулагдсан Эдийн засгийн сэргэлтийг дэмжих тухай хуулийн төсөлд эдгээр чиглэлээр зарим тодорхой арга хэмжээ тусгагдсан байсан. Гэвч уг хуулийн төслийг өргөн бариагүй, нэр болон агуулгыг дахин өөрчилж өргөн барихаар болжээ.

Эдгээрээс ядуурлыг бууруулах зорилт нь эдийн засгийн ерөнхий өсөлтийн хүрээнд зарим нэг байдлаар хэрэгжиж болох ч тэгш бус байдлыг бууруулах, дундаж давхаргыг бэхжүүлэх гэх мэт нэн ялангуяа цар тахлын үед хурцаар тавигдаж буй асуудлыг тусгайлан авч үзэж бодлого, зорилт дэвшүүлээгүй байна.

Нэн ялангуяа богино хугацааны эрсдэлүүдийг удирдах нь энэ төрлийн бодлогын хамгийн эхний зорилтууд байх учиртай боловч “Шинэ сэргэлтийн бодлого” богино хугацааны бүтцийн болон гэнэтийн шокийн асуудлуудаа орхиж урт хугацаанд биелүүлж үр дүн нь гарах том төслүүд рүү түлхүү анхаарсан байна. Тухайлбал, Дэлхийн банкнаас 2021 онд нийтэд танилцуулсан “Монголын эдийн засгийн тойм: Тусламжаас өсөлт өөд” тайланд ойрын хугацаанд эдийн засагт тулгарах эрсдэл буюу даван гарах

шаардлагатай сорилтуудыг дараах байдлаар тодорхойлсон нь бодлогын төсөлд үндсэндээ багтаагүй байна (ДБ, 2021). Үүнд:

- Цар тахлыг үр дүнтэй хянаж чадахгүй тохиолдолд ойрын саруудад нийгмийн эрүүл мэнд, эдийн засагт асар их хор хохирол учрах нь дамжиггүй. Эдийн засгийн өсөлтөд эрсдэл учруулж болох бусад хүчин зүйлсэд дэлхий дахин дахь цар тахлын дараа дараагийн давлагааны түүхий эдийн үнэд (ялангуяа, нүүрс болон зэс) үзүүлж болох сөрөг нөлөө, цаг агаарын тааламжгүй нөхцөл байдал (ган гачиг, үер, зуд), банкны секторын бүтцийн өөрчлөлт, шинэчлэл гацах зэргийг дурдаж болно.
- Цар тахал хөгжингүй орнуудын эдийн засгийг боомилсон хэвээр, үүнээс гадна магадгүй АНУ, БНХАУ-ын худалдааны тодорхойгүй байдал үргэлжилбэл гадаад эрэлт, экспортын түүхий эдийн үнэ (ялангуяа зэс), санхүүгийн захын хувьд маш ноцтой үр дагавар бий болно.
- Инфляц өсөж, гадаад секторын дарамт нэмэгдэхийн хэрээр мөнгөний бодлогын төлөв дунд хугацаанд чангарах магадлалтай буюу одоогийн тэлэх бодлогыг үргэлжлүүлэх орон зай хумигдана.
- Банкны зээлийн зохицуулалтыг цаашид зөөлрүүлэх, сулруулах нь дунд хугацаанд эдийн засгийн өсөлт, тогтвортой байдалд таамаглаж байгаагүй үр нөлөө үзүүлж болзошгүй.
- Айл өрхүүдийн гуравны хоёр хүртэл хувьд хөл хорио, ажлын байр, бизнес хаагдсан болон бусад шалтгаанаар хөдөлмөр эрхлэлт нь зогссон байна. Энэхүү нөлөө түр зуурын мэт байсан боловч ядуу иргэдийн хувьд урт хугацаанд ажлын байраа алдах эрсдэлтэй байна.
- Ядуу өрхийн хувьд цалин хөлс нь өрхийн орлогын 60 гаруй хувийг бүрдүүлдэг хэдий ч орлогынх нь гуравны нэгийг хүүхдийн мөнгө болон нийгмийн бусад халамж, тэтгэмж бүрдүүлж буйг улсын төсөв цаашид даах боломж хомс болж байна.

Хүснэгт 3. Монгол Улсад тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэхээр дэвшүүлсэн зорилтууд

	ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТ	БОДЛОГЫН ЗОРИЛТУУД
Гадаад сектор	Гадаад худалдааг хөнгөвчлөх, түүхий эдийн үнийн өсөлтийг ашиглаж экспортын өсөлтийг хангах	<ul style="list-style-type: none"> - Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ. - Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
	Олон улсын худалдааны өрсөлдөх чадварыг сайжруулах: тээвэр, логистик, хилийн боомт	
	Бүс нутгийн нийлүүлэлтийн сүлжээ, интеграцид нэгдэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан, дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттай үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжинэ. - ОХУ-аас БНХАУ руу дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолой барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

Эдийн засгийн бүтэц	Гадаад валютын гарах урсгалыг сааруулах бүтцийг дэмжих	Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг ханган, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.
	Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг бага байлгах	
	Уул уурхайн салбараас хамаарах эдийн засгийн савлагааг бууруулах	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн, эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна. - Хөдөө орон нутагт түүхий эдийн нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.
	Эдийн засгийн төрөлжилт: Үйлдвэрлэл, инновацыг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлнэ. - Шинжлэх ухаанд суурилсан, өндөр технологи, блокчейн, хиймэл оюуны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ.

<p>Эрчим хүчний хэрэгцээгээ дотооддоо хангах, экспортлох</p>	<ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх, шугам сүлжээг шинээр барьж байгуулан, хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ. - Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн, усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана. - Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ. - Зүүн Хойд Азийн супер сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангана. - Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.
<p>Төвлөрлийг сааруулж, орон нутгийн эдийн засгийг дэмжих</p>	<ul style="list-style-type: none"> - Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна. - Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ.

	<p>Улаанбаатар хотын түгжрэл, агаар хөрсний бохирдол гэх мэт тулгамдсан асуудлуудыг шийдэх</p> <p>Улаанбаатар хотын нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулан, багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэн, гол ба үндсэн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчилж, олон түвшний уулзвар байгуулан хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын түгжрэлийг бууруулна.</p>
<p>Бизнесийн сектор</p>	<p>Гадаадын хөрөнгө оруулалтыг татах, диверсификацлах</p>
	<p>Хөрөнгө оруулалт, бизнесийн орчны зохицуулалт, хуулийн орчин, институцийн чадавхыг сайжруулах</p>
	<p>Жижиг дунд бизнесийг хамгаалах, сэргэлтийг дэмжих</p>
<p>Аялал жуулчлалын салбарыг сэргээн хөгжүүлэх</p>	
<p>Экологийн хувьд тогтвортой, ногоон хөгжлийн суурийг тавих</p>	<ul style="list-style-type: none"> - Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ. - Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усны хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.

	<ul style="list-style-type: none"> - Байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдийг Улаанбаатар хот болон аймаг, орон нутагт бүсчлэн байгуулна. - Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно. 	
	Хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэх	ХАА үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.
Өрхийн сектор	Ажиллах хүчний оролцоо, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ялгаварлалыг бууруулах	
	Нийгмийн халамжийг зорилтот бүлгүүдэд чиглүүлэх	
	Ядуурлыг бууруулах	
	Тэгш бус байдлыг бууруулах, дундаж давхаргыг хамгаалах	
Төрийн сектор	Төсвийн бодлогыг тогтворжуулах, алдагдлыг бууруулах	
	Төсвийн тэлэлтийг сааруулж өрийг бууруулах	
	Баялгийн сангийн тогтолцоог бүрэн нэвтрүүлж, үндэсний хуримтлалын суурийг тавих	Үндэсний баялгийн сангийн тогтолцоог
	Ирээдүйн өв сангийн бүрэн бүтэн байдлыг хадгалах	бүрдүүлэх тухай хуулиудыг өргөн барьж батлуулах
	Төсвийн хуримтлал бий болгох	
	Улсын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх	

Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, ТӨК-иудын реформ хийх	<ul style="list-style-type: none"> - Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоож, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна. - Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.
Тэтгэвэр, нийгмийн даатгалын шинэчлэл хийх	
Авлигатай тэмцэх, засаглалыг сайжруулах	<ul style="list-style-type: none"> - Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна. - Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ. - Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.
Эдийн засгийн өсөлтийг дэмжих татварын шинэчлэл	
Мөнгө, санхүүгийн сектор	Улсын секторын өрийн эрсдэлийг бууруулах, гадаад төлбөрийг дахин санхүүжүүлэх
	Мөнгөний бодлогын чадавх бүрдүүлэх
	Монгол банкны тэнцлийг аливаа төсвийн шинжтэй хөтөлбөрт оролцуулахгүй байх, бодлогын бие даасан байдлыг хангах

Санхүүгийн салбарын тогтвортой байдал, банкуудын хөрөнгийн чанар, мэдээллийн ил тод, үнэн зөв байдлыг хангах	Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт (саарал, хар жагсаалт), Европын холбооны "Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгуудын жагсаалт"-д орохгүй байх, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулахаас сэргийлнэ.
Банкны салбарын реформыг хэрэгжүүлэх	
Хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих	

Түүнчлэн “Шинэ сэргэлтийн бодлого”-д Монгол Улсад тулгарч буй асуудлыг шийдэх бус улам даамжруулах зөрчилдөөнтэй зарим бодлого ч багтсан байгаа нь анзаарагдав. Тухайлбал, уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг бууруулах сорилт тулгарч байгаа бөгөөд бодлогын танилцуулгад энэ талаар дурдсан ч малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр барих, шахмал модон эдлэлийн үйлдвэр барих гэх мэт цөөн төслийг эс тооцвол хэрэгжүүлэхээр төлөвлөсөн дийлэнх “хөгжлийн” гэх төслүүд нь олборлох салбартай шууд хамааралтай байв. Тухайлбал үүнийг “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслүүд хэмээн 20 багц төсөл төлөвлөсний 18 нь хатуу дэд бүтэц, үйлдвэрлэлийн цогцолбор хөгжүүлэх төсөл байгаагаас харж болно. Үүнээс тав нь олборлох салбарын, тав нь зам тээвэр, хилийн боомтын хүчин чадлыг өргөжүүлэх (ихэвчлэн олборлох бүтээгдэхүүний экспортыг дэмжих), дөрөв нь эрчим хүчний салбарт хэрэгжихээр байна (Хавсралт).

Мөн Монгол банкиг аливаа төсвийн шинжтэй хөтөлбөрт оролцуулахгүй байх, бодлогын бие даасан байдлыг хангах нь тулгамдсан асуудал боловч үүний эсрэгээр тус банкнаас Хөгжлийн банканд санхүүжилтийн эх үүсвэр

олгох; шатахууны нөөц бүрдүүлэх зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрийг банканд олгох; ипотекийн зээлийг үргэлжлүүлэн санхүүжүүлэх гэх мэт заалтууд бодлогын хүрээнд дагалдан гарах хуулийн төсөлд суужээ.

Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн төрийн захиргааны төв байгууллагатай байх тухай заалтыг Засгийн газар хэрэгжүүлэхгүй бүтэн жил хагас өнгөрсний дараа дөнгөж саяхан буюу 2022 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр Эдийн засгийн хөгжлийн яам байгуулах шийдвэр гаргасан. Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд чухал үүрэг гүйцэтгэх энэ институт эмхлэгдэн байгуулагдаж, үйл ажиллагаа нь жигдрэх, шаардлагатай боловсон хүчнээр бүрэн хангагдах хүртэл багагүй цаг хугацаа шаардлагатай. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудыг хэрхэн яаж хэрэгжүүлэх арга замаа бид өнөөг хүртэл тодорхойлоогүй хэвээр байна. Түүхий эдийн экспортын орлого, үнэ ханшаас хамаарч эдийн засаг нь ихээхэн хэлбэлзэж байдаг манай улсын хувьд бодлогыг зөв төлөвлөж, хэрэгжүүлэх институцийн чадавх маш чухал гэдгийг олон улсын бүхий л байгууллагууд удаа дараагийн зөвлөмж, тайландаа тусган анхааруулж ирсэн билээ.

3. БОДЛОГЫН ЧИГЛЭЛҮҮДЭЭ СОНГОСОН БАЙДАЛ

Бодлогын чиглэлүүд

“Шинэ сэргэлтийн бодлого” нь эдийн засгийн шинэчлэлийн цогц шинжтэй бодлого болохын хувьд олон хувилбар гаргаж харьцуулан үнэлэх нь энэхүү тоймын хүрээнд хийгдэх ажлын хүрээнээс давсан, илүү их нөөц, цаг хугацаа шаардах ажил болох юм. Түүнчлэн УИХ-д өргөн баригдсан төслийг дагалдуулан санал болгож байгаа бодлогын хүлээгдэж буй үр нөлөө, хувилбаруудын давуу ба сул талыг авч үзсэн судалгаа, хөгжлийн төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийн талаарх мэдээлэл зэргийг Засгийн газар боловсруулаагүй эсвэл нийтэд ил болгоогүй байна. Иймд энэ хэсэгт бодлогын хувилбаруудыг харьцуулан үнэлэхийн оронд бодлогын голлох чиглэлүүд олон улсад ямар буй, “Шинэ сэргэлтийн бодлого” нь ямар чиглэлүүдийг сонгож төвлөрсөн байгаа талаар авч үзлээ.

Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх “Төсвийн Зөвлөл”-өөс Цар тахлын үеийн төсвийн бодлогын тойм гаргасан. Уг тоймд дурдсанаар цар тахлын үеийн төсвийн бодлого нь (i) эрүүл мэндийн хохирлын эсрэг салбарын бэлэн байдал, найдвартай ажиллагааны баталгааг хангах; (ii) хөл хорио, хязгаарлалтаас үүдэлтэйгээр иргэд, аж ахуйн нэгжийн амьжиргаа, бизнесийн үйл ажиллагаанд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах; (iii) эдийн засгийн сэргэлтийг дэмжиж аль болох хурдтайгаар хямралаас гарах; (iv) эдийн засаг, эрүүл мэндийн системийн дархлааг сайжруулж дараа дараагийн болзошгүй шокийн эсрэг чадавх бүрдүүлэх зорилгод үйлчлэх шаардлагатай. Эдгээрээс дунд хугацаанд хэрэгжих гурав, дөрөвдүгээр зорилго нь хямралын үед голлосон төсвийн тэлэх бодлогыг үргэлжлүүлэх төдийгөөр бус, илүү өргөн хүрээнд эдийн засгийн бүтцийн шилжилтийг харах шаардлагатай юм (А.Батпүрэв, 2021). Чухам эдгээр зорилгыг хэрэгжүүлэх бодлогын сонголтуудыг “Шинэ сэргэлтийн бодлого” шиг цогц хөтөлбөрт суулгаж өгөх учиртай.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас хэвлүүлсэн “Шинэ чиглэлүүд: Тэнхээтэй сэргэлт болон тогтвортой, хүртээмжтэй ирээдүйн төлөө суурь бодлогууд” (OECD, 2020) тайланд Засгийн газруудын Ковидын дараах эдийн засгийн бодлого нь (i) Нөөцийн шилжилтийг удирдах; (ii) Хүн нэг бүрийг дэмжих; (iii) Тогтвортой байдлыг эргүүлж авчран эдийн засгийн тамир тэнхээг бэхжүүлэх гэсэн гурван тулгууртай байх шаардлагатай гэж үзжээ. Эдгээрийг дэлгэрүүлэн Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4. Тэнхээтэй, тогтвортой, хүртээмжтэй сэргэлтийн бодлогын бүтэц, ЭЗХАХБ

<p>НӨӨЦИЙН ШИЛЖИЛТ <i>Улам бүр дижиталчлагдаж буй шинэ эдийн засгийн орчинд бүтээмжийн өсөлтийг дэмжих</i></p>	<p>ИРГЭДЭЭ ДЭМЖИХ <i>Шинэ ажлын байр, орлогын эх үүсвэр рүү шилжихийг дэмжих, тэгш боломж бүрдүүлэх</i></p>	<p>ТОГТВОРТОЙ БАЙДАЛ БА ТАМИР ТЭНХЭЭ <i>Илүү тогтвортой, бат бэх суурьтай өсөлтийг бий болгох</i></p>
<ul style="list-style-type: none"> - Нөөцийг бүтээмжтэй ашиглалтад чиглүүлж хуваарилах; - Хөрөнгө оруулалтыг дэмжих; - Бизнес шинэчлэл, инновацыг дэмжих; - ААН-үүдийн өр, төлбөрийн чадварын асуудлыг шийдэх; - Санхүүгийн салбарын тогтвортой байдал, хүртээмжийг сайжруулах; - Бизнесийн шинэ боломжуудыг нээх; - Зах зээлийг чөлөөлж илүү үр ашигтай, динамик болгох. 	<ul style="list-style-type: none"> - Ажлын байр нэмэгдүүлж, шилжилт, оролцоог дэмжих; - Ажилтны ур чадварыг хөгжүүлэх; - Зорилтот нийгмийн халамж хэрэгжүүлэх, халамжийн хөтөлбөрөөс үе шаттай гарах; - Ядууралд унах эрсдэлтэй бүлэгт туслах. 	<ul style="list-style-type: none"> - Үргэлжилсэн шокоос сэргийлэх, эрсдэлийг удирдах; - Хямралын сөрөг нөлөөллийг арилгах; - Нийлүүлэлтийн гинжин хэлхээг сэргээх, шинээр бүтээх; - Эдийн засгийн бүтцийн сул талуудыг шийдэх; - ЗГ-ын өрийн удирдлагыг сайжруулах, гадаад өрийг бууруулах; - Төсвийн болон мөнгөний бодлогын чадавхыг бэхжүүлэх; - Эдийн засаг, бизнесийн сэргэлтийг хурдасгах.

Жишээ: Өрсөлдөөн, худалдааны нээлттэй байдал, төрийн өмчийн реформ, хувьчлал, хөдөлмөрийн зах зээлийн уян хатан зохицуулалт, татварын шинэчлэл гэх мэт.

Жишээ: Боловсрол, мэргэжлийн сургалтын тогтолцоог шинэчлэх, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл, дундаж давхаргыг дэмжих бодлого.

Жишээ: Эрүүл мэндийн систем, даатгалын тогтолцоог бэхжүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, засаглал, хуульт ёсыг сайжруулах.

Энэхүү тэнхээтэй, тогтвортой, хүртээмжтэй сэргэлтийн бодлогын санал болгож буй бүтэцтэй харьцуулж үзвэл “Шинэ сэргэлтийн бодлого” нь эдийн засгийн тамир тэнхээ бий болгох, тэр дундаа дэд бүтцийн болон үйлдвэрлэлийн хүчин чадал бүрдүүлэх дундаас урт хугацааны бодлогын сонголтуудад төвлөрсөн байна. Мөн засаглал, зохицуулалтын орчныг шинэчилж төрийн оролцоо, хүнд суртлыг бууруулах, цар тахлын үеийн нэг томоохон сөрөг үзэгдэл болох авлигыг бууруулах чиглэлээр зарим бодлого дэвшүүлжээ.

Гэсэн хэдий ч хямралын сөрөг нөлөөг арилгах, “шинэ эгэл” орчинд бизнесийнхэн, мөн иргэдээ дэмжих болон нөөцийн шилжилт хуваарилалтыг үр дүнтэй удирдах тал нь орхигдсоноос гадна төсөл хөтөлбөрүүдийг төрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ингэснээр засгийн газрын гадаад, дотоод өр нэмэгдэж төсвийн бодлогын чадавх улам бүр сулрах төлөвтэй байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарч байгааг анхааран, цаашид хурдасгах шаардлагатай гэж үзэж дээрх бодлогыг боловсруулсан бол юуны өмнө эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөд анхаарал хандуулах, улсын төсөв хэлэлцэн баталж буй өнөөгийн алдаа согогтой тогтолцоог өөрчлөх, төсвийн сахилга батыг чанд мөрдөн Төсвийн хүрээний мэдэгдэлд тусган баталсан дээд хязгаарыг өөрчлөхгүй байх, улсын төсвийн хөрөнгийг ач холбогдол багатай зүйлд үрэн таран хийж буй өнөөгийн нөхцөл байдлыг арилгах гэх зэргээр бодлогын шинжтэй суурь өөрчлөлтүүдийг зайлшгүй хийх шаардлагатай юм.

Олон улсын туршлага: Ирланд Улсын жишээ

Ирланд Улсын Засгийн газраас батлан гаргасан “Эдийн засгийн сэргэлтийн төлөвлөгөө” (Government of Ireland, 2021) нь дараах агуулгатай байх бөгөөд эдийн засгийн хэмжээ, бүтцийн хувьд Монгол Улстай адилтгах тал ихтэй юм (Хүснэгт 5).

Хүснэгт 5. Ирланд Улсын Эдийн засгийн сэргэлтийн төлөвлөгөө

ТУЛГУУР БОДЛОГУУД	БОДЛОГЫН ХҮРЭЭ
Төсөв санхүүгийн тогтвортой, тэнхээтэй байдлыг хангах	<ul style="list-style-type: none">- Татварын шинэчлэл;- Нийгмийн хамгаалал, даатгалын бодлого.
Хөдөлмөрийн зах зээлийг өргөжүүлж, оролцоо, ур чадварын хөгжлийг дэмжих замаар ажил эрхлэлтийг дэмжих	<ul style="list-style-type: none">- Одоогийн дэмжлэгүүдээс үргэлжлүүлэх;- Ажилгүйдлийг бууруулах;- Залуучуудын ажил эрхлэлт;- Хөдөлмөрийн захын саад бэрхшээлүүдийг бууруулах;- Сургалт, ур чадварын хөгжүүлэлт.
Зорилтот дэмжлэгүүд болон бүтээмж, чадавхыг нэмэгдүүлэх бодлогоор дамжуулж аж ахуйн нэгжүүдээ бэхжүүлэх	<ul style="list-style-type: none">- Жижиг, дунд бизнесийг дэмжих;- Үндэстэн дамнасан бизнесүүд, олон улсын худалдаа;- Сэргэлтэд шаардлагатай хөрөнгө оруулалтууд;- Дижитал шилжилт;- Бизнесүүдийн чадавх, байгальд ээлтэй байдлыг дэмжих;- Өрсөлдөөнт байдлыг нэмэгдүүлэх;- Инновацад суурилсан мэдлэгийн эдийн засаг.

Стратегийн хөрөнгө оруулалт, бүсчилсэн хөгжил, амьдралын чанарыг дэмжих бодлогуудаар сэргэлтийг **тэнцвэртэй, хүртээмжтэй байлгах**

- Тогтвортой стратегийн хөрөнгө оруулалт;
 - Орон нутгийн тэнцвэртэй хөгжил;
 - Хотуудыг хөгжүүлэх;
 - Дундын арлын боломжууд;
 - Зайнаас ажиллах болон жендерийн тэгш байдал;
 - Амьдралын стандартыг сайжруулах.
-

4. БОДЛОГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУРУУД, ДҮГНЭЛТ

Энэхүү тойм судалгааны хүрээнд эдийн засгийн сэргэлтийн бодлогын алтернатив хувилбаруудыг дэвшүүлж харьцуулан үнэлэх зорилго тавиагүй болно. Мөн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын дагалдах танилцуулгын хүрээнд ийм харьцуулалт хийсэн мэдээлэл, судалгаа байхгүй болохыг дээр дурдсан. Иймд энэ хэсэгт бодлогын хувилбарыг үнэлэхэд ашигладаг зарим нийтлэг шалгуур үзүүлэлтээр боломжит мэдээллийн хүрээнд өргөн баригдсан төсөлд дүгнэлт өглөө.

Бодлогын баримт бичиг төлөвлөлт, хэлэлцүүлэг

- Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг нь урт, дунд, богино хугацааны баримт бичиг байна гэж заасан. 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр УИХ-ын чуулганы хуралдаанаар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын Хараа 2050” бодлогын баримт бичгийг батлан гаргаснаар урт хугацааны хөгжлийн баримт бичиг, хөгжлийн зорилтууд тодорхой болсон. Улмаар энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэн боловсруулж УИХ-аас батлан гаргасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө нь хөгжлийн дунд хугацааны баримт бичиг болсон билээ. Ийнхүү Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан бүхий л баримт бичгийг нэгэнт боловсруулж УИХ-аас батлан гаргасан нөхцөлд “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг чухам ямар хуульд үндэслэн, ямар үндэслэл шаардлагаар боловсруулсан нь ойлгомжгүй байна.

- “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг боловсруулж, хэлэлцүүлсэн явц, цаг хугацааны дарааллаас үзвэл уг баримт бичгийг эрх барьж буй Монгол Ардын Нам (МАН)-ын зүгээс боловсруулж, 2021 оны 12 дугаар сарын 6-наас 8-ны өдрүүдэд болсон МАН-ын ээлжит Их хурлаар хэлэлцсэн. Үүний дараа уг баримт бичгийн төслийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар хэлэлцэн, улмаар 12 дугаар сарын 27-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлжээ. Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслийг УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэж, 12 дугаар сарын 30-ны өдөр “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолыг баталжээ. Өргөн барьсан бодлогын баримт бичгийг ердөө гурав хоногийн дотор хэлэлцэн баталж байгаа нь УИХ-ын гишүүд уг бодлогын баримт бичигтэй нухацтай танилцсан, олон талаас нь хэлэлцсэн гэж үзэх аргагүй байна.
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого, 2021 оны тогтоолоор баталсан “Шинэ Сэргэлтийн бодлого”-ыг харьцуулж үзвэл үндсэндээ эдгээр бодлогод тусгагдсан зорилтуудын 90-95 хувь нь давхардаж байна. Ийнхүү нэг жилийн өмнө хэлэлцэн баталж, улмаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн таван жилийн төлөвлөгөөнд нэгэнт тусгагдсан зорилтуудыг дахин шинэ бодлого байдлаар найруулан боловсруулж, хэлэлцэн батлах нь ач холбогдол багатай юм. Ийнхүү УИХ-аас “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэлэлцэн баталж, түүний дотор тэргүүлэх ач холбогдол бүхий зорилтуудыг тусгайлан заасан нөхцөлд өнгөрсөн 2020 онд батлан гаргасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нэмэлт тодотгол хийх эсэх нь тодорхойгүй, эргэлзээтэй хэвээр байна.

Хамаарал

Цаг үеийн шаардлага буюу тулгарч буй асуудалтай холбогдон чадаж буй эсэх өнцгөөс нь авч үзвэл “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төсөл нь ойрын хугацааны асуудалтай бага зэрэг хамааралтай, дунд-урт хугацааны асуудалд түлхүү чиглэжээ.

- Коронавируст цар тахлаас үүдэлтэй богино хугацааны эдийн засгийн эрсдэлийг хэмжих “Ковид-19 Эмзэг байдлын индекс”-ээр Монгол Улс эмзэг байдал дундаж буюу дунд зэргийн эрсдэлтэй гэж дүгнэгджээ. Үүнээс цар тахал зэрэг шокод өртөмхий байдал болон түүний эсрэг эдийн засгийн бодлогын хариу арга хэмжээ авах боломжийг илэрхийлсэн хоёр үзүүлэлтээр “маш өндөр эрсдэлтэй” гэсэн ангилалд орсон байна. Эмзэг байдлын индекс нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор тухайн эдийн засагт тулгарч буй богино хугацаанд анхаарах шаардлагатай асуудлуудыг тодруулж өгч буйгаараа ач холбогдолтой юм.
- Уг индекс болон бусад эх сурвалжуудыг ашиглан Монгол Улсын эдийн засагт богино болон дунд хугацаанд тулгарч буй 32 асуудлыг жагсааж зургаан бүлэгт ангилснаас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төсөлд 10 асуудал буюу 32 хувийг нь авч үзэж асуудлаа дэвшүүлсэн байна. Мөн дөрвөн асуудлыг бусад асуудалтай холбоотойгоор ямар нэг байдлаар хөндөж үзсэн гэж үзэж болохоор байгаа бөгөөд үлдсэн 18 асуудал буюу 56 хувь нь огт хөндөгдөөгүй байна.
- Гадаад өрийг бууруулах, төсвийн зардлыг бууруулж хөрөнгө оруулалтын удирдлагыг чанаржуулах, хуримтлал үүсгэх замаар төсвийн бодлогын чадавхыг бэхжүүлэх, Төв банкны хараат бус байдлыг бэхжүүлж төсвийн шинжтэй хөтөлбөрүүдээс гарган санхүүгийн системийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, улмаар инфляц, гадаад валютын ханшийн өсөлтийн эсрэг мөнгөний бодлогын чадавх бүрдүүлэх, нийлүүлэлтийн гинжин хэлхээг богино хугацаанд сэргээж бизнесийн секторыг дэмжих, ажиллах хүчний шилжилтийг бүтцийн өөрчлөлттэй уялдуулан зохион байгуулах гэх мэт асуудлуудыг “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төсөлд онилоогүй байна.

Оновчтой, Үр ашигтай байдал

УИХ-д өргөн баригдсан төсөлд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүлээгдэж буй үр нөлөө, хувилбаруудын давуу ба сул талыг авч үзсэн судалгаа,

хөгжлийн төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг дагалдуулан ирүүлээгүй эсвэл огт хийгдээгүй байх тул бодлогын оновчтой байдал, өгөгдсөн хугацаа, нөөцөөр оптимал үр дүнд хүрч буй эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилт болон хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь тулгарч буй сорилт, олон улсын туршлагатай харьцуулахад төдийлөн оновчтой бус, урт хугацаанд үр нөлөө нь гарах хатуу дэд бүтэц барьж байгуулахад голлон чиглэжээ. Тухайлбал, урт хугацааны эдийн засгийн тамир тэнхээ бий болгох, тэр дундаа дэд бүтцийн болон үйлдвэрлэлийн хүчин чадал бүрдүүлэх дундаас урт хугацааны бодлогын сонголтуудад төвлөрсөн байна. Засаглал, зохицуулалтын орчныг шинэчилж төрийн оролцоо, хүнд суртлыг бууруулах, цар тахлын үеийн нэг томоохон сөрөг үзэгдэл болох авлигыг бууруулах чиглэлээр зарим бодлого дэвшүүлснийг нь мөн дурдах нь зүйтэй.

Харин хямралын сөрөг нөлөөг арилгах, “шинэ эгэл” орчинд бизнесийнхэн мөн иргэдээ дэмжих болон нөөцийн шилжилт хуваарилалтыг үр дүнтэй удирдах тал нь орхигдсон, төсөл хөтөлбөрүүдийг төрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ингэснээр засгийн газрын гадаад, дотоод өр нэмэгдэж төсвийн бодлогын чадавх улам бүр сулрах төлөвтэй байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөнөөр ашиглана гэж буй боловч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилт, түүний эх үүсвэр, нийтийн санхүүгийн эрсдэл, өгөөжийн талаар мэдээлэл байхгүй байна. Тухайлбал:

- Төсөлд дэвшүүлсэн зорилт болон хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь тулгамдсан асуудалд үндэслэн тодорхойлсон 37 сорилтын 22 буюу 59 хувийг ямар нэг байдлаар шийдвэрлэх агуулгатай байна.
- Ядуурлыг бууруулах зорилт нь эдийн засгийн ерөнхий өсөлтийн хүрээнд зарим нэг байдлаар хэрэгжиж болох ч тэгш бус байдлыг бууруулах, дундаж давхаргыг бэхжүүлэх гэх мэт нэн ялангуяа цар тахлын үед хурцаар тавигдаж буй олон асуудлыг тусгайлан авч үзэж бодлого, зорилт дэвшүүлээгүй байна.
- Хэдийгээр нэг бодлогын баримт бичгээр бүх сорилтыг шийдвэрлэх зорилт тавих нь хүндрэлтэй боловч “Шинэ сэргэлтийн бодлого”

нь 10 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд “Ковид-19 цар тахалтай үргэлжлүүлэн тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлж буй сөрөг үр дагаврыг арилган хүндрэлийг даван туулахын зэрэгцээ Монгол Улсын хөгжлийг урт, дунд хугацаанд хязгаарлаж буй асуудлуудыг шийдвэрлэх” гэж зорилгоо тодорхойлсон тул аль болох олон бэрхшээл сорилтод хариулт өгөх иж бүрэн шинжтэй байх шаардлагатай юм.

- Тулгарч буй асуудлыг шийдэх бус улам даамжруулах зөрчилдөөнтэй зарим бодлого ч анзаарагдаж байна. Тухайлбал, уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг бууруулах сорилт тулгарч байгаа бөгөөд бодлогын танилцуулгад энэ талаар дурдаж буй боловч малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр барих, шахмал модон эдлэлийн үйлдвэр барих гэх мэт цөөн төслийг эс тооцвол хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “хөгжлийн” гэх төслүүд нь олборлох салбартай шууд хамааралтай байв.

Хэрэгжих боломж

Шинэ сэргэлтийн бодлогын төслийн танилцуулгад дурдсанаас үзвэл энэхүү бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд эхний ээлжид 57 их наяд төгрөгийн, цаашид төсөл хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхэд 110-120 их наяд орчим төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай гэж тусгажээ.

Монгол Улсын төсвийн нийт орлого жилдээ 15-16 их наяд төгрөг, үүний дотор нэг жилийн хөрөнгө оруулалтын төсөв 3-4 их наяд төгрөг орчимд л байдаг. Мөн Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 33 тэрбум ам. долларт, Засгийн газрын нийт өрийн хэмжээ 27 их наяд төгрөгт хүрээд буй макро эдийн засгийн өнөөгийн ийм орчин нөхцөлд хэчнээн чухал зорилт дэвшүүлсэн ч түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг босгох, бүрдүүлэх боломж, магадлал тун бага байна.

Олон Улсын Валютын сан (ОУВС), Дэлхийн банкнаас гаргаж буй сүүлийн үеийн таамаглал, судалгаанаас үзвэл 2022 онд түүхий эдийн үнэ ханшийн өсөлт төдийлөн тааламжтай бус мөн хэлбэлзэл ихтэй байж болзошгүй байна. Ковидын тархалтын эрсдэлээс хамаарч 2021 оны 10 дугаар сараас хойш манай улсын түүхий эдийн экспортын биет хэмжээ эрс буурсан, Замын-

Үүдийн хилийн боомт үндсэндээ хаалттай гурван сар гаруй болж байгаа нөхцөлд Монгол Улсын 2022 оны төсөвт урьдчилан тооцоолж тусгасан экспортын орлого, төсвийн орлого оны эхний хагас жилд ихээхэн хэмжээгээр тасалдаж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна. Ойрын гурван жилд Монгол Улсын төлөх ёстой гадаад бондын төлбөрийн хэмжээ гурван тэрбум гаруй ам. доллартой тэнцэж байгаа бөгөөд ковидын дараах үеийн эдийн засгийн сулхан өсөлтийн үед дээрх гадаад өр төлбөрийг төлөхүйц хэмжээний хөрөнгийн эх үүсвэр хуримтлуулах боломжгүй нь тодорхой байна.

Хөрөнгө санхүүгийн хувьд ийм эрсдэлтэй, хүндрэлтэй нөхцөлд шинээр хэрэгжүүлэх төслүүдэд шаардлагатай томоохон дүн бүхий хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх боломж гарахгүй, бий болохгүй байх эрсдэл өндөр, харин гадаад өрийн дарамт цаашид улам бүр нэмэгдэх эрсдэлтэй байна. Иймээс “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн таван жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт зорилтыг хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний хөрөнгийн эх үүсвэр шаардагдах тооцооллыг дахин нарийвчлан сайтар тооцоолж үзэх, нөгөө талаар гадаад өрийн дарамт, хөрөнгө санхүүгийн өнөөгийн байдалд нийцүүлэн дээрх баримт бичгүүдэд тусгагдсан олон тооны төсөл, хөтөлбөрийг ач холбогдлоор нь дараалалд оруулах, цаг хугацааны хувьд аль хэсгийг нь хойшлуулах боломжтой вэ? гэдгийг дахин тооцож боловсруулах шаардлагатай байна.

Мөн бодлогын төслийн танилцуулгад дурдсан хүрэх үр дүн нь бодитоор хэрэгжих боломжтой гэхэд эргэлзэхүйц асуудлууд багагүй байна. Тухайлбал, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлснээр “урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар зургаан хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого хоёр дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ. Боомтын хүчин чадлыг гурав дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг хоёр дахин өсгөнө” гэжээ. Гэвч 10 жилд нэг хүнд ногдох үндэсний орлогыг хоёр дахин нэмэгдүүлэх нь эдийн засгийн дундаж өсөлтийг зургаан хувьд барих зорилтоор хэрэгжих боломжгүй, одоо 58 хувь байгаа ажиллах хүчний оролцоог 65 хувьд хүргэх үндэслэл, судалгаа байхгүй байна.

Тогтвортой, Үр нөлөөтэй байдал

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын төсөл нь урт хугацааны, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан гэж дүгнэж байна. Харин бодлогын хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн хүрэх үр дүн, тэдгээрийг хэмжих үзүүлэлтүүд тодорхой бус, зардал-үр өгөөжийн судалгаа байхгүйгээс “мөрөөдлийн жагсаалт” шинжтэй харагдаж байна. Өөрөөр хэлбэл, “Шинэ сэргэлтийн бодлого”-д хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн төслийн жагсаалтаас гадна түүнийг хэрхэн хэрэгжүүлэх арга замын талаар огт тусгаагүй, энэ талаар бодож төлөвлөсөн зүйл өнөөг хүртэл нийтэд огт танилцуулагдаагүй байна. Иймээс “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийг эдийн засгийн бодлого гэж нэрлэх боломжгүй бөгөөд **хөрөнгө оруулалтын жагсаалт төдий баримт бичиг** болжээ.

Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд олон жилийн өмнөөс манай улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгөхдөө боломжоосоо давсан мөрөөдлийн жагсаалт батлахгүй байх, Монгол Улсын эдийн засаг нь гадаад зах зээл, түүхий эдийн үнэ ханшаас ихээхэн хамааралтай савлагаа ихтэй, үүний улмаас төсвийн орлогын бүрдэлт ихээхэн савласаар байгааг удаа дараа сануулж, анхааруулж ирсэн юм. Гэтэл манай УИХ, Засгийн газар, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид энэхүү зөвлөгөөг өнөөг хүртэл ойлгоогүй, үл хэрэгссэн хэвээр байгаа нь энэ байдлаас тодорхой харагдаж байна.

Нэгэнт УИХ-аас батлан гаргасан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг цаашид хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан зорилтуудыг Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрт тусган боловсруулж, улмаар УИХ-аар батлуулах. Ийнхүү Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрт тодотгол хийснээр ирэх жилүүдэд улсын төсвийн төслийг боловсруулахад чухам аль зорилтод түлхүү ач холбогдол өгөх вэ? гэдэг нь тодорхой болох бөгөөд Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр нь улсын төсвийн төслийг боловсруулах суурь баримт бичиг болох ёстой. Ийм байдлаар бодлогын уялдаа,

ач холбогдол, хэрэгжүүлэх төслүүдийн эрэмбэ дарааллыг тогтоож өгөөгүй нөхцөлд улсын төсөвт ач холбогдол багатай, хэт олон төсөл тусгагдах, улмаар байгаа багахан хөрөнгийн эх үүсвэрийг тарамдуулах эрсдэлтэй юм.

- Мөн дээр дурдсанчлан УИХ-аас батлан гаргасан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудаа ач холбогдлын хувьд эрэмбэлэх, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг нарийвчлан тооцох, уг хөрөнгийн эх үүсвэрийг ойрын жилүүдэд бүрдүүлэх боломжтой эсэх тооцооллыг хийх шаардлагатай.
- Манай улсад яамд, агентлаг хоорондын бодлогын уялдааг хангах асуудал ихээхэн учир дутагдалтай байсаар ирсэн тул ирэх 2022 оны намар боловсруулах 2023 оны улсын төсвийн төсөл боловсруулахаас эхлэн бодлогын уялдааг хэн хэрхэн хангаж, зөв оновчтой төлөвлөлт хийх вэ? гэдэг тогтолцоог зөв бүрдүүлэх, зохицуулах шаардлагатай болно.
- Мөн үүний зэрэгцээ дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд түнш орнууд, хөрөнгө оруулагчдын оролцоо, дэмжлэг зайлшгүй шаардлагатай тул тэдгээр түншлэгч, олон улсын байгууллага, хөрөнгө оруулагчтай бодлогоо уялдуулах асуудалд онцгой анхаарах, 2022 оны намартаа багтаан “Хандивлагчдын уулзалт” зохион байгуулж, ирэх жилүүдийн бодлого, үйл ажиллагааныхаа талаар сайтар зөвлөлдөх шаардлагатай болно.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

АХБ, *Монгол Улсын Хүртээмжтэй бөгөөд Тогтвортой Өсөлтийн Үнэлгээ 2017-2020*, 2021, Азийн Хөгжлийн Банк.

А.Батпүрэв, *Цар тахлын үеийн төсвийн бодлого*, 2021, Нээлттэй Нийгэм Форум, Төсвийн зөвлөл.

Davradakis, E., & et.al., *The EIB COVID-19 Economic Vulnerability Index – An analysis of countries outside the European Union*, 2020, European Investment Bank.

Дэлхийн банк, *Монголын эдийн засгийн тойм: Тусламж дэмжлэгээс өсөлт өөд*, 2021, Дэлхийн Банк.

Д.Ган-Очир, *Монголын хөгжлийн зам: сургамж, сорилт, боломж*, 2020, УБ.

OECD, *New horizons: Structural policies for a strong recovery and a sustainable, inclusive and resilient future*, 2020, Paris: Secretary-General of the OECD.

Government of Ireland, *Economic Recovery Plan*, 2020, Dublin.

Засгийн газар, *"Шинэ сэргэлтийн бодлого"*, УИХ-ын тогтоолын төсөл, 2021.

IMF, *World Economic Outlook*, 2021, International Monetary Fund.

ХАВСРАЛТ

“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

д/д Төслийн нэр

НЭГ. БООМТЫН СЭРГЭЛТ

- | | |
|---|---|
| 1 | Төмөр замуудыг холбох төслүүд
(Гашуунсухайт-Ганцмод хил холболт, Тавантолгой-Цогтцэцийг төмөр замаар холбох төсөл) |
| 2 | Төмөр замын сүлжээг шинэчлэн сайжруулах төслүүд
(Төмөр замын төв коридор, Эрээнцав-Баянтүмэн төмөр зам, Сүхбаатар-Замын-Үүд чиглэлийн төмөр замын төв коридорыг хос замтай болгох төсөл) |
| 3 | Шинэ төмөр замын сүлжээг байгуулах төслүүд
(Зүүнбаян-Ханги, Чойбалсан-Хөөт-Бичигт, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн) |
| 4 | Замын-Үүд-Алтанбулаг олон улсын транзит хурдны зам барих, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбох төслүүд
(Ханги, Цагаандэл Уул, Бургастай, Цагааннуур, Тэс, Арцсуурь, Ханх, Бага Илэнхи, Зэлтэр, Ульхан, Хавирга, Сүмбэр, Баянхошуу, Бичигт) |
| 5 | “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг өргөтгөж, олон улсын агаарын ачаа тээврийн транзит төв болгох, орон нутгийн онгоцны буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслүүд |
| 6 | Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх ачаа тээврийн терминалуудыг байгуулах төсөл
(Гашуунсухайт, Шивээхүрэн, Бичигт, Ханги, Эрээнцав, Арцсуурь, Алтанбулаг, Замын-Үүд) |

ХОЁР. ЭРЧИМ ХҮЧНИЙ СЭРГЭЛТ

- 7 Дулааны цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх төслүүд
(ДЦС 3, ДЦС 2, Чойбалсан, Улаанбаатар хотын дулаан хангамжийн тархмал эх үүсвэр болох Амгалан ДС, ДЦС-4-ийн зуух болон хийн эх үүсвэрүүд)
- 8 Эрчим хүчний шинэ эх үүсвэр барих төслүүд
(Тавантолгой ДЦС, Эрдэнэбүрэн УЦС, Эгийн гол УЦС, Төвийн бүсийн 5 дахь эх үүсвэр, Багануур ДЦС)
- 9 Эрчим хүчний дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний төслүүд
(Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай, Тавантолгой ДЦС-Оюутолгой, Сайншанд-Цагаансуварга, Багануур-Өндөрхаан, Багануур-Чойр, Мандалговь-Арвайхээр, Багануур-Налайх-Улаанбаатар)
- 10 Байгальд ээлтэй, шинжлэх ухаан, дэвшилтэт технологид суурилсан эрчим хүчний төслүүд
(Цөмийн, ногоон-устөрөгч, байгалийн хий, сэргээгдэх эрчим хүчний төслүүд)

ГУРАВ. АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН СЭРГЭЛТ

- 11 Газрын тос боловсруулах төслүүд
(Газрын тосны нөөц хайгуулын төсөл, газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой, дагалдах барилга байгууламжийн төсөл)
- 12 Тавантолгой болон бусад нүүрсний ордуудыг иж бүрнээр нь ашиглах төслүүд
(Нүүрс баяжуулах үйлдвэр, усан хангамжийн төсөл, ил уурхайн олборлолтын шилдэг технологи нэвтрүүлэх төсөл, далд уурхайн төсөл)
- 13 Эрдэнэт, Оюутолгой болон бусад зэсийн ордуудыг иж бүрнээр нь ашиглаж, зэс боловсруулалтыг нэмэгдүүлэх төслүүд
(Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл, исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл)
- 14 Аж үйлдвэрлэл, технологийн парк цогцолборуудыг барих төслүүд
(Гангийн үйлдвэр байгуулах төсөл, уул уурхай-металлурги-химийн үйлдвэрлэлийн төсөл, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төсөл)

- Хөдөө аж ахуй, газар тариалан, хүнсний дотоодын хангамжийг сайжруулах төслүүд
- 15 (Дарханы арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах төсөл, махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж барих техникийн шинэчлэл хийх төсөл)

ДӨРӨВ. ХОТ, ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ

- Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах төслүүд
(Хотын нийтийн тээврийг шинэчлэх болон тулгуурт гүүрэн байгууламж
- 16 бүхий багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлэх төсөл, нийслэл Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам” барих төсөл)

- Төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүс, хот байгуулах дэд бүтэц болон барилга байгууламжийн төслүүд
- 17 (Хөшигтийн хөндийд эдийн засгийн бүс байгуулах, Залуус хороолол, боомт болон орон нутагт суурьшлын бүс хөгжүүлэх төслүүд)

ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

- Байгальд ээлтэй дэвшилтэт технологид суурилан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах төслүүд
- 18 (“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, энгийн болон аюултай хог хаягдлын төвлөрсөн эко байгууламж байгуулах төсөл)

- Усны нөөцийг хуримтлуулж, говийн бүсийн ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслүүд
- 19 (“Хөх морь” төсөл)

ЗУРГАА. ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ

- Иргэн, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдад ээлтэй төрийн оновчтой бүтцийг тодорхойлох, төрийн үйлчилгээг цахимжуулах төслүүд

ISBN 9919-9840-3-5



9 789919 984035